



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар Б/45

Дэлгэрхаан сум

**Тээврийн хэрэгслийн татвар хураалт техникийн
үзлэг тооллогыг явуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, 59 дүгээр зүйлийн 59.1 дэх заалт, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний А/37 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд авто тээврийн хэрэгслийн техникийн үзлэгийг 2025 оны 04 дүгээр сарын 28, 29, 30-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Батнасан	Засаг даргын орлогч
Гишүүд:	Б.Энхцэцэг	1-р багийн Засаг дарга
	Н.Цэнддолжин	2-р багийн Засаг дарга
	Б.Мөнхболд	3-р багийн Засаг дарга
	Д.Оюунчимэг	4-р багийн Засаг дарга
	Г.Батнасан	5-р багийн Засаг дарга
	П.Буянтогтох	Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахмад
	Н.Баасандорж	Цагдаа, цагдаагийн ахлагч

Нарийн бичгийн дарга: Х.Гандулам Татварын улсын байцаагч

3. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

4. Сумдад батлагдсан хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт техникийн хяналтын үзлэрт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг Хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад (П.Буянтогтох)-д даалгасугай.

5. Заагдсан хугацаанд авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураахыг Татварын улсын байцаагч (Х.Гандулам)-д, хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулах албан хаагчдыг үүрэгжүүлж хариуцлагатай ажиллахыг Хэсгийн төлөөлөгч цагдаагийн ахмад (П.Буянтогтох), Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Дээрх тээврийн хэрэгслийн татвар хураалт техникийн урьдчилсан үзлэг тооллогыг зохион байгуулж 2025 оны 04 дүгээр сарын 30-нд ажлын хэсгийн гишүүд илтгэх хуудсыг танилцуулахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН



مسین کسب

SC/m مفتیس

10 50 500
بصر بصر بصر

مستحقان کما یشاء من مستحقین و مستحقین مستحقان
مستحقان مستحقین کما یشاء من مستحقین

[illegible]

6. ... بهیچ گامی که به سمت راست می‌رویم، در هر گام، $0 \leq x \leq 1$ و $0 \leq y \leq 1$ را داریم.

27. ... من غير ان يكون له نصيب في الميراث ...
 (غير ان يكون له نصيب في الميراث) ...
 (غير ان يكون له نصيب في الميراث) ...

[illegible]

۵. هتسافسو (نک) م تلمیظین . اسفیز نر یسیطر
۶. ویرقمعر اسفیز , اسفیز نر یسیطر

۱۰) به عنوان مثال، در مورد شرکت‌های تولیدی، می‌توانیم فرض کنیم که شرکت‌ها در دو بخش تولید و خدمات فعالیت می‌کنند. در این صورت، می‌توانیم از مدل‌های ترکیبی استفاده کنیم که همزمان با مدل‌های تولیدی و خدماتی را پوشش دهد. این مدل‌ها می‌توانند شامل متغیرهای مختلفی مانند هزینه‌های تولید، هزینه‌های خدمات، درآمد، و ... باشند. این مدل‌ها می‌توانند به شرکت‌ها کمک کند تا بتوانند به بهترین شکل ممکن، منابع خود را مدیریت کنند و به اهداف خود دست یابند.

[illegible][illegible]

